

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанаас хоцроох, он дамжуулан
хойшлуулах нийтлэг зөрчил илэрч байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2024/18-09-ШТА-ГА

Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг орон нутгийн иргэдийн санал, хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөөгүй байна.....5

А.1 Бага дүнтэй төсөл, арга хэмжээг он дамжуулах, улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх, зураг, төсөвт тавигдах шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.....5

А.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан байна.....6-7

А.3 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна.....8

БҮЛЭГ Б. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэрээний хугацааг хоцроох, ХАА амжилтгүй болсноос ТАХ-г он дамжуулсан байна.....8

Б.1. Төсөвт өртөг нь нэмэгдсэнээс шалтгаалж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд дуусаагүй байна.....8-11

Б.2 Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хийгээгүйгээс батлагдсан зураг, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүсэх зөрчлүүд гарсан байна.....12

Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.....12

Б.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулж ажилласан байна.....13

БҮЛЭГ В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 91.5 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.....13

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсний дагуу хийгдээгүйгээс ашиглалтгүй байна.....13

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 8.5 хувь буюу 5 ТАХ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.....14

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	15
ДҮГНЭЛТ:	16
САНАЛ:	16
ЗӨВЛӨМЖ:	17
АЛБАН ШААРДЛАГА.....	18
ТУШААЛ.....	19-20
ХАВСРАЛТ.....	21-23

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нийцлийн аудит
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
СЗД	Сумын Засаг дарга
СНАГ	Санхүү-нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХ-ТШЗ	Тендерийн өгөгдлийн хүснэгт – Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХО	Хөрөнгө оруулалт
MNS	Mongolian national standard

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:
	• Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх; • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх; • Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Дорнод аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2023 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, сумдын Засаг дарга нар, захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга шалгуур үзүүлэлт	зүй, Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 200, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, Я.Зориг, аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.
	Аудитын дэд төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны дотор батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж хэлэлцүүлэн, тайланг 05 дугаар сарын 16-нд Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг орон нутгийн иргэдийн санал, хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөөгүй байна.

А.1 Бага дүнтэй төсөл, арга хэмжээг он дамжуулах, улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх, зураг, төсөвт тавигдах шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт


Дорнод аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хийх төсөл, арга хэмжээ төлөвлөөгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/964 дугаартай албан бичгээр Сангийн Сайдад хүргүүлсэн байна. Тус жагсаалтаар 145,624.2 сая төгрөгийн өртөгтэй 24 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр санал хүргүүлсэн боловч нэг ч төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна. Тухайлбал: Чойбалсан хотын орон сууцны байрнуудын сантехникийн шугам хоолой муудсанаас иргэд зэвтэй ус хэрэглэж эрүүл мэндээрээ хохирч байгаа тул Чойбалсан хотын ус хангамжийн шугам сүлжээг шинэчлэх саналыг хүргүүлсэн ч 2023 оны төсөвт тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

1. Аймгийн төсвийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд өмнөх оноос шилжиж ирсэн 1,654.8 сая төгрөгийн 12 ТАХ, 1,071.6 сая төгрөгийн их засварын 10 ТАХ, 1,225.8 сая төгрөгийн барилга байгууламж 9 ТАХ, 270,0 сая төгрөгийн 1 зураг төсөв боловсруулах ажил, тоног төхөөрөмж 571.9 сая төгрөгийн 9 ТАХ, нийт 4,794.1 сая төгрөгийн 41 ТАХ батлагдсан байна.

график 1



Графикаас харахад өмнөх оноос шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн дүн хөрөнгө оруулалтад баталсан нийт төсвийн 34.0 хувийг эзэлж байна. Энэ нь шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бууруулж олон жижиг төсөл, арга хэмжээг жил дамжуулан хэрэгжүүлснээр

барилгын материалын үнийн өсөлт, цаг хугацаа алдалт зэргээс шалтгаалан зорилтот хүрэх үр дүндээ хүрэхгүй байх, цаашид дараа дараагийн жилүүдэд дахин засвар, тохижилт хийгдэхээр төсөвт тусгагдаж хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэж болзошгүй байна. Жишээ нь: Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилтод 95.0 сая төгрөг баталж 2021 оноос эхлэн 2023 онд 25.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосноор дуусгавар болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” зарчимтай нийцэхгүй байна.

2. Дорнод аймгийн 2023 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2022 оны 13/11 дүгээр тогтоолоор батлан, 2023 оны 15/02, 17/02, 19/09 дугаар тогтоолуудаар 3 удаа өөрчлөлт хийсэн байна.

Дээрх төсөвт хийсэн 3 удаагийн өөрчлөлтөөр Төрийн аудитын байгууллагаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй 4,076.8 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг нэмж, 85.9 сая төгрөгийн 2 арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7-д “Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө” 34 дүгээр зүйлийн 34.2.3-д “энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 1. Төсөл, арга хэмжээнд орсон өөрчлөлт

д/д	Үзүүлэлт	ТАБ-аар хянагдаагүй		Төсөвт өртгийг нэмэгдүүлсэн		Нийт өөрчлөлтийн	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	37	4,079.8	2	85.9	39	4,165.7
дүн		37	4,079.8	2	85.9	39	4,165.7

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны хөрөнгө оруулалтын батлагдсан хуваарь

Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй, төсөвт өртгийг нэмэгдүүлсэн ТАХ-ний жагсаалтыг тайлангийн /хавсралт №1/ хүснэгтээр харуулав.

Дорнод аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх албан шаардлага өгөгдсөн байна.

3. Улсын төсвийн байгууллагуудад орон нутгийн төсвөөс нийт 590.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн зарцуулсан байна. Үүнд:

1. "Өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин (Асралт-Үйлс ӨЭМТ, Ягаан цээнэ ӨЭМТ) 50.0 сая төгрөг
2. Политехник коллежийн барилгын дээврийн засварт 50.0 сая төгрөг
3. Төрийн тусгай албан хаагчдын орон сууц (Тагнуулын газар) 420.0 сая төгрөг
4. Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж (Прокурорын газар) 20.0 сая төгрөг
5. Мал эмнэлгийн лабораторийн багаж, төхөөрөмж (Мал эмнэлгийн газар) 20.0 сая төгрөг
6. Авто техникийн шинжилгээний лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж (Шүүхийн шинжилгээний алба) 30.0 сая төгрөг

Орон нутгийн төсвөөр улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийж байгаа нь орон нутгийн иргэдийн саналын дагуу хийгдэх хөрөнгө оруулалтад зарцуулах төсөв, хөрөнгө буурах эрсдэлтэй байна.

4. Барилгын ажлыг бараа худалдан авах тендерээр зарлаж, барилгын тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус байгууллагаар бариулахаар тооцож төлөвлөсөн байна. Үүнд: 1. Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын нэгдсэн авто гражийн материал

450.0 сая төгрөг, 2. Хүүхдийн шинэ цэцэрлэг барих барилгын материал (Матад сум, Мэнэн баг) 198.0 сая төгрөг.

Энэ нь стандарт шаардлага хангахгүй барилга байгууламж баригдах эрсдэлийг үүсгэж байна. Мөн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 4 дүгээр зүйлийн “4.1.1 “ажил” гэж барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, буулгах, шинэчлэх, геологийн судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг болон түүнийг дагалдан нийлүүлэх барааг,” гэсэнтэй нийцэхгүй байна.

Барилгын ажлыг бараа худалдан авах тендерээр зарлаж, барилгын тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн асуудал илэрсэн тул гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн Төрийн аудитын тухай хуулийн 35¹ дугаар зүйлд заасны дагуу Прокурорын байгууллагад шилжүүлсэн.

5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 26 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын санд бүртгэлтэй балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2010 оны 04-92 УБА улсын дугаартай Toyota Land cruiser 200 маркийн авто машиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасаж, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газарт бүртгэж авсан байна. Уг авто машины урсгал засварыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгаж баталсан байна. Үүнд: Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслийн засвар 30.0 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24. “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; 29 дүгээр зүйлийн 29.4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана. гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Булган сумын эхийн амрах байрны зурагт агааржуулалтын хоолойг тусгаагүй зургийг баталсан байна. Энэ нь барилгад агаарын урсгал солилцоо чөлөөтэй хийгдэхгүйгээс чийгтэж улмаар хана, тааз мөөгөнцөртөх эрсдэлийг бий болгож байна.

A.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан байна.

Дорнод аймгийн төсвийн хөрөнгөөр 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад дараа онд шилжих 1,654.8 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг 2023 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд бүрэн тусгаж ажилласан байна.

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023.12.04-ний 19 дүгээр хуралдаанаар аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 1.2.2.11-т тусгагдсан Цэцэрлэгийн зориулалттай барилга, орон сууц худалдан авах 480.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний тендерт оролцогч ирээгүй шалтгаанаар хэрэгжээгүй тул төсвийн

¹ 35.1 Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ.

тодотголоор хасагдсан байна. Энэ нь төсөвт өртгийг багаар төлөвлөлттэй холбоотой байна.

А.3 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 1,654.8 сая төгрөгийн 12 ТАХ, шинээр хэрэгжих их засварын 1,864.4 сая төгрөгийн 16 ТАХ, Барилга, байгууламжийн 1,777.6 сая төгрөгийн 12 ТАХ, тоног төхөөрөмжийн 1,457.3 сая төгрөгийн 18 ТАХ, ТЭЗҮ-ийн 25.2 сая төгрөгийн 1 ТАХ-ний гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийн комиссын актыг үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна.

БҮЛЭГ Б. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэрээний хугацааг хоцроох, ХАА амжилтгүй болсноос ТАХ-г он дамжуулсан байна.

Б.1. Төсөвт өртөг нь нэмэгдсэнээс шалтгаалж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд дуусаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтаас эрх нь орон нутагт шилжсэн 6,881.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 барилга, байгууламж, дэд бүтцийн ажил байна.

Үүнээс 1 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, 2 төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа дуусаагүй байна. Үүнд:

1. *Спорт заалны барилга /Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль/ - төсөвт өртөг 1,431.0 сая. "Тод сүндэрэл" ХХК гэрээний хугацаанд зураг, төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.*
2. *Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/ - төсөвт өртөг 3,292.5 сая. "Дуутын нуруу" ХХК 2022-2024 онд гүйцэтгэж дуусахаар гэрээ байгуулсан байна. Ажлын бодит гүйцэтгэл 80 хувьтай байгаагаас дотуур байр, урлаг заалны үндсэн хийц, цахилгаан, дулааны ажлууд дуусаж, гадна, дотор шавар, өнгөлгөө, пассатны ажлууд хийгдэж байна.*
3. *Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/ - төсөвт өртөг 2,157.5 сая. "Авто агро" ХХК 2021-2024 он хүртэл гүйцэтгэж дуусахаар байгуулж, 2023 онд Читийн гудамжны авто зам дагасан бохирын шугамын ажлыг гүйцэтгэсэн байна. Зураг төсвийн дагуу 2024 онд Читийн гудамжны авто замыг шинэчлэх ажил хийгдэнэ. Нийт ажлын бодит гүйцэтгэл 29.4 хувьтай байна.*



Гадна пассадын ажил гүйцэтгэж буй байдал



Барилгын ажлын өрлөг, өрөө тасалгааны зохион байгуулалт, цахилгаан, дулаанд холбох ажлууд бүрэн дуусч, гадна тохижилт, дотор заслын ажлууд үлдсэн байна.

Өнгөрсөн 2023 онд ТЕЗ-д эрх нь шилжээгүй 519,659.20 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээ байгаагаас Зам тээврийн хөгжлийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, Эрүүл мэндийн яам, Эрчим хүчний яам, Батлан хамгаалах яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн хувьд гүйцэтгэл удаашралтай байна.

1. “Сургуулийн барилга, 640 суудал /Дорнод, Хэрлэн сум, 3 дугаар баг/” – анхны төсөвт өртөг 4,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2019-2022 он. “Шимт газар” ХХК тус ажлыг 3,897.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч 2024 оны төсвийн тухай хуульд 5,438.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй болж өөрчлөгдөн 2024 оны 04 дүгээр сарын байдлаар ажлын бодит гүйцэтгэл 30 хувьтай буюу удаашралтай байна.
2. “Музейн барилга /Дорнод, Хэрлэн сум/” – анхны төсөвт өртөг 3,363.3 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2019-2022 он. “Сүхжин” ХХК нь 2,999.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч 2024 оны төсвийн тухай хуульд 4,478.5 сая төгрөг болж өөрчлөгдөн 2024 оны 04 дүгээр сарын байдлаар ажлын бодит гүйцэтгэл 75 хувьтай буюу удаашралтай байна.
3. “Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/” – анхны төсөвт өртөг 1,842.6 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2019-2022 он. “Стандарт рэзидэнс констракшн” ХХК тус ажлыг 1,493.5 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж, 2024 оны төсвийн тухай хуульд 2,902.1 сая төгрөг болж өөрчлөгдөн 2024 оны 04 дүгээр сарын байдлаар ажлын бодит гүйцэтгэл 97 хувьтай байна. Гаднах инженерийн байгууламж, дулааны шугамын ажлыг орон нутгийн төсвөөр шийдвэрлэж, ажил нь 2024 онд багтаан дуусахаар байна.
4. “Дотуур байрны барилга, 150 ор /Дорнод, Цагаан-Овоо сум/” – анхны төсөвт өртөг 1,661.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2019-2022 он. “Өндөр баганат” ХХК тус ажлыг 1,377.8 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж, 2024 оны төсвийн тухай хуульд 1,963.6 сая төгрөг болж өөрчлөгдөн 2024 оны 04 дүгээр сарын байдлаар ажлын бодит гүйцэтгэл 90 хувьтай байна.
5. “Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 68.3 км /Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум/ - анхны төсөвт өртөг 66,740.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2022-2024 он. “Монгол зам” ХХК тус ажлын 1-р багцын ажлыг 2023-2024 онд гүйцэтгэхээр 8,319.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, замын далан босгох ажил Баян-Уул сум хүртэл үргэлжилж, замын гүүрний байгууламжийн ажлууд хийгдэж байна.
6. Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/ - анхны төсөвт өртөг 49,820.0, сая төгрөг хэрэгжих хугацаа 2022-2024 он. “Билэгт зам” ХХК тус ажлын 1-р багцад 33,993.2 сая төгрөг, “Da Xing Co” Ltd компани 2-р багцад 50,899.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2024 оны 04-р сарын байдлаар 1-р багц буюу Цагаан давааны өвөр хүртэлх ажил хийгдэж байна.



Хэрлэн сумын 640 суудалтай сургуулийн барилга гэрээний хугацаанд дуусаагүй, ажлын бодит гүйцэтгэл 30 хувь



Музейн барилга гэрээний хугацаанд дуусаагүй, ажлын бодит гүйцэтгэл 75 хувь. 2024 онд нэмж төсөв батлагдсан.



Хэрлэн сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэг гэрээний хугацаанд дуусаагүй, гадна дулааны шугамын ажил шийдэгдэж, барилгын бодит гүйцэтгэл 97 хувь



Цагаан-Овоо сумын 150 ортой дотуур байрны барилга гэрээний хугацаанд дуусаагүй, 2024 онд төсөв нэмэгдэж, барилгын бодит гүйцэтгэл 95 хувь



Норовлин - Баян-Уул чиглэлийн замын далан, гүүрний байгууламжийн ажил хийгдэж байна.



Баян-Уул - Ульхан боомт чиглэлийн автозамын ажлын багц-1-ийн ажил Цагаан давааны өвөр хүртэлх ажил хэвийн үргэлжилж байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Гэрээний хугацаанаас хоцроох, он дамжуулан хойшлуулах зэрэг нийтлэг зөрчил илэрч байна.

Аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 10,228.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, он дамжуулсан нийтлэг зөрчил илэрч байна.

Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанаас 1-30 хоног хоцроож хүлээлгэж өгсөн 212.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ байна. Үүнээс гэрээний тусгай нөхцөлийн дагуу алданги тооцсон 126.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 2. “Гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээ”

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний хугацаанаас хэтэрсэн хоног	Гүйцэтгэгчийн нэр	Шалтгаан тайлбар
1	Орон нутгийн өмчийн барилга,байгууламжийн засвар /багц-1/	7.0	6	“Мирандир” ХХК	Гэрээний хугацаанаас 6 хоног хэтэрч, алдангийг тооцсон байна.
2	Орон нутгийн өмчийн барилга,байгууламжийн засвар /багц-10/	29.6	26	“Дүүлэн нис” ХХК	Гэрээний хугацаанаас 26 хоног хэтэрч, алдангийг тооцсон байна.
3	Мал эмнэлгийн лабораторын багаж, төхөөрөмж	20.0	7	“Монветмед” ХХК	Гэрээний хугацаанаас 7 хоног хэтэрч, алдангийг тооцсон байна.
4	Чойбалсан хотын төв авто замд гэрлэн дохио суурилуулах ажилд шаардлагатай тоног төхөөрөмж	70.0	30	“Инносолюшн” ХХК	Гэрээний хугацаанаас 30 хоног хэтэрч, алдангийг тооцсон байна.
Нийт		212.8			

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний судалгаа

Тайлант хугацаанд бүрэн дуусгаагүй, он дамжуулан хэрэгжүүлэх 1,120.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 3. “Тайлант онд хэрэгжиж дуусаагүй, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ”

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэрэгжих хугацаа /ИТХ-ын тогтоол/	Гүйцэтгэгчийн нэр	Шалтгаан тайлбар
1	Дорнод аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал (Багц 2, 3)	172.8	2022-2023	Багц-2 “Батсүндэрэл” ХХК Багц-3 “Гидродизайн инновац” ХХК	Багц-1. Хуучин хогийн цэгийг дарж булшлах ажлын зураг төсөвт магадлалын дүгнэлт хүлээгдэж байгаа. Багц-2. Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн зураг төсөвт техникийн нөхцөл хүлээгдэж байгаа. Тус ажлуудын гүйцэтгэл 80 хувь.
2	Хэвтээ тэнхлэгийн хойд болон урд авто замд хурд сааруулагч хийх,тэмдэглэгээ шинэчлэх /Хэрлэн сум/	140.0	2023-2023	“ЗБИБ” ХХК	Тендер оройтож зарлагдсанаас өнгөрсөн онд ажил нь дуусаагүй, ХХААГ-ын урд байрлах хурд сааруулагч хийгдээгүй. Гүйцэтгэл 65 хувь.
3	Цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламж худалдан авах /Хэрлэн сум 6,11 баг/	480.0	2023-2023	-	ААН шалгараагүй, хэрэгжээгүй.
4	Гүний худгийн цооног гаргах	100.0	2023-2023	“Сатабу” ХХК	Тендерийг 12 удаа зарлаж, ААН шалгараагүйгээс гэрээг дараа онд хэрэгжүүлэхээр сунгасан.
5	Гүний худгийн цэвэршүүлэх тоног төхөөрөмж /халх гол, буйр нуур/	117.6	2023-2023	“Ирмүүн бармат” ХХК	Тендерийг 2 удаа зарлаж, гэрээг 2024.05 дугаар сард дуусахаар байгуулсан байна.
6	Төрийн байгууллагын албан хэрэгцээнд компьютер,тоног төхөөрөмж /Хэрлэн сум/	110.5	2023-2023	“Анд пирамид констракшн” ХХК	Тендерийг 2 удаа зарлаж, гэрээг 2024.01 дүгээр сард дуусахаар байгуулсан байна.
Нийт		1,120.9			

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний судалгаа

Б.2 Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хийгээгүйгээс батлагдсан зураг, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүсэх зөрчлүүд гарсан байна.

Батлагдсан зураг, төсөв, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй гүйцэтгэсэн 433.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 4. “Батлагдсан зураг, төсөв, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй ТАХ”

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэгчийн нэр	Шалтгаан тайлбар
1	Спортын талбай (Хэрлэн сум 3, 11 дүгээр баг)	343.6	“Дорнын мөнгөн хийц” ХХК	Ажлын зураг, төсөвт 3, 11 дүгээр багийн тоглоомын талбайд тус бүр 6 гэрлийн шон байрлуулахаар заасан боловч 3-р багт 2, 11 дүгээр багт 4 гэрлийн шонг байрлуулсан байна. Ажлын даалгаварт нэмж тодотгон 11 дүгээр багийн тоглоомын талбайн хэмжээг нэмэгдүүлэн гүйцэтгэсэн байна.
2	Тариалан эрхлэгчдийн хүнсний ногоо болон малчдын малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зөврийн сууц, тоног төхөөрөмж	90.0	“Дорнын их өгөөж” ХХК	Техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт 5 ширхэг зөврийн сууц нийлүүлэхээр заасан боловч гүйцэтгэгч нь 2 ширхэг сууцыг 35.5 сая төгрөгөөр нийлүүлж батлагдсан тоо хэмжээнд хүрээгүй байна.

Үүрэг даалгаврын хэрэгжилтээр хүлээж авсан 455.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл, доголдол үүссэн 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- “Сэвсүүлийн голын гарам, хоолой (Дашбалбар сум) – төсөвт өртөг 90.0 сая төгрөг. Гүүрийн байгууламжийн зүүн урд хэсэгт цууралт үүсэж, бүтээцэд нуралт үүсэх эрсдэлтэй байна.
- “АДАПТ төсөлтэй хамтран “Онцгой байдлын үед хэрэглэх хадлан, өвс тэжээлийн агуулах 2 суманд барих ” ажлын аймгийн төсвөөс гаргах 15 хувь (төслийг хэрэгжүүлэх сумдаас 15%, АДАПТ төслөөс 70%)” /Баяндун, Чулуунхороот сум/ - төсөвт өртөг 360.0 сая төгрөг. Хашааны зүүн, баруун хаалганы доод талын бетон цутгалт, өвсний сүүдрэвчийн налуулгын бетон цутгалт тус тус бутарч, хагарал үүссэн нь ашиглалтын шаардлага хангахгүй байна. Агуулахын пандусыг 2024 оны 04-р сард хийх үүрэг даалгавар өгөгдсөн байна. Мөн Чулуунхороот суманд хийгдсэн тэжээлийн агуулахын хаяавчийг 2024 оны 04-р сард хийх үүрэг даалгавар өгөгдсөн байна.
- “Нийтийн ариун цэврийн байгууламж Чойбалсан сум, Хавирга хилийн боомт” – төсөвт өртөг 95.0 сая төгрөг. Тус ажлыг комисс хүлээж авахдаа дэврийн хар цаасны ам дарах, фасад засварлах ажлыг 2024 оны 04-р сард багтаан гүйцэтгэх үүрэг даалгавар өгсөн байна.

Б.3. Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтаас эрх нь орон нутагт шилжсэн 6,881.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 барилга, байгууламж, дэд бүтцийн ажил байгаагаас Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн спорт заалны барилга баригдаж дуусан улсын комисс хүлээн авсан байна. Хэрлэн сумын 1 дүгээр сургууль тус заалыг үндсэн хөрөнгөд бүртгэж авсан байна.

Хэрлэн сум 2 дугаар багийн 180.7 сая төгрөгийн өртөг бүхий эрчим хүчний дэд станцыг Хэрлэн сумын ЗДТГ-т, 420.0 сая төгрөгийн өртөгтэй Төрийн тусгай албан хаагчдын орон сууц (Тагнуулын байрыг авч оронд нь өгсөн) Орон нутгийн өмчийн

газарт тус тус бүртгэлтэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Дашбалбар сумын цахилгаан хангамжийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-ын 1000 КВа чадалтай дэд өртөө нийт 6,886.9 сая төгрөгийн хөрөнгийг Дашбалбар ОНӨААТҮГ бүртгэсэн байна. Энэ нь орон нутгийн төсөвт дарамт үүсгэх, ашиглалттай холбоотой зардлыг орон нутаг хариуцах эрсдэлтэй байна. Төрийн өмчийн байгууллагын өмчлөлд шилжүүлэх боломжтой хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж авсан байна.

Б.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.” гэж зааснаар уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1², 4 дүгээр зүйлийн 4.1.3³, 6 дугаар зүйлийн 6.4⁴, 6.4.4⁵ заалтын дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулах үүргийг хүлээсэн байна.

Тулган баталгаажуулалтаар Шилэн дансны тухай хуульд зааснаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 59 мэдээллийг бүрэн байршуулж ажилласан байна.

БҮЛЭГ В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 91.5 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсний дагуу хийгдээгүйгээс ашиглалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтаас эрх нь орон нутагт шилжсэн 6,881.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 барилга, байгууламж, дэд бүтцийн ажил байна. Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн спорт заалны барилга - төсөвт өртөг 1,431.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил бүрэн дууссан байна. Хэрлэн сумын 1 дүгээр сургууль тус заалыг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. Харин сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/ - төсөвт өртөг 3,292.5 сая төгрөгийн, босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/ - төсөвт өртөг 2,157.5 сая төгрөгийн нийт 2 ажлын ашиглалтад оруулах хугацаа болоогүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн 59 төсөл, арга хэмжээний ашиглалтын явцыг аудитаар газар дээр нь очиж тулган

² төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

³ тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

⁴ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

⁵ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

баталгаажуулахад дараах 3 төсөл арга хэмжээг төлөвлөсний дагуу ашиглаагүй байна. Үүнд:

1. Хэрлэн сумын 11 дүгээр баг 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламжтай болгох ажил, бохирын шугам 53.5 сая төгрөг, зөөврийн ариун цэврийн байгууламж 33.0 сая төгрөг нийт 86.5 сая төгрөг (Бохирын шугам, зөөврийн ариун цэврийн байгууламжийн холболтын ажил хийгдээгүй)
2. Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна зогсоол 33.1 сая төгрөг (төлөвлөсөн байршлаас өөр газарт Стандарт, хэмжил зүйн хэлтсийн урд хийгдсэн. Тус цэцэрлэг нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зүүн талдаа зогсоол хийгдсэн байсан.)
3. Тариалан эрхлэгчдийн хүнсний ногоо болон малчдын малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зөөврийн сууц 35.5 сая төгрөг (ЖДҮ төв 2 зөөврийн сууц бүртгэж авсан ч гүйцэтгэгч компанийн хашаанд байна. Байршуулах газрын асуудлыг шийдээгүй) хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн ч 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар ашиглалтгүй байна.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 8.5 хувь буюу 5 ТАХ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх нь орон нутагт шилжсэн 6,881.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 барилга, байгууламж, дэд бүтцийн ажил байна. Үүнээс 1 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, 2 төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа дуусаагүй байна. Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн спорт заалны барилга баригдаж дуусаж улсын комисс хүлээн авсан байна. Хэрлэн сумын 1 дүгээр сургууль тус заалыг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. Төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн 59 төсөл, арга хэмжээнээс дараах 5 төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

1. Хэрлэн сумын 11 дүгээр баг 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламжтай бий болгох ажил. бохирын шугам 53.5 сая төгрөг, зөөврийн ариун цэврийн байгууламж 33.0 сая төгрөг нийт 86.5 сая төгрөг.
2. Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна зогсоол 33.1 сая төгрөг.
3. Хэвтээ тэнхлэгийн хойд болон урд авто замд хурд сааруулагч хийх, тэмдэглэгээ шинэчлэх /Хэрлэн сум/ 87.0 сая төгрөг. (хүйтэрснээс шалтгаалж бүрэн хийгдээгүй)
4. Хуучин хогийн цэгийг дарж булшлах ажилд дэмжлэг үзүүлэх /Баянтүмэн сум/ 30.0 сая төгрөг (Хогийн цэгийг нүүлгээгүй, дахин хог хаяж байна. Хог нь хийсэж зүүн цемэнтэн гүүр орчмоор тархсан)
5. Тариалан эрхлэгчдийн хүнсний ногоо болон малчдын малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зөөврийн сууц 35.5 сая төгрөг (зөөврийн сууц 5-ыг төлөвлөсөн ч 2 нь нийлүүлэгдсэн. ашиглатгүй) эдгээр ажлууд төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@domod.gov.mn
Цахим хуудас: Domod.gov.mn

2024.05.15 № 1/1171
танай 2024.05.13-ны № 350 -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Танай 2024 оны 350 албан бичгээр ирүүлсэн
“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар ирүүлсэн
зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

Х.Нарангуйхал:
Б.Батмалгай:
Майланг Оюунт
Баталмажурал.

2/16
2024.г.

212407262

Б.Батмалгай 2/16

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

А.1 Бага дүнтэй төсөл, арга хэмжээг он дамжуулах, улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх, зураг, төсөвт тавигдах шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.

А.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан байна.

А.3 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна.

Б.1 Төсөвт өртөг нь нэмэгдсэнээс шалтгаалж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд дуусаагүй байна.

Б.2 Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хийгээгүйгээс батлагдсан зураг, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүсэх зөрчлүүд гарсан байна.

Б.3 Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Б.4 Төсвийн ерөнхийлөн захирагч нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээллэж ажилласан байна.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсний дагуу хийгдээгүйгээс ашиглалтгүй байна.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 8.5 хувь буюу 5 ТАХ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Аудитаар нийт 10,442.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 678.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 9,764.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх 1 санал, нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Улсын төсвийн эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг захиалагч яамд үр дүнтэй зохион байгуулах. (Аудитын тайлангийн 9 дүгээр хуудас)

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнд анхаарч, бага дүнтэй төсөл, арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Д.Дамдинбазарт:**

1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулж, зураг төсөвт заасан тоо хэмжээний дагуу ажлыг гүйцэтгүүлэх.

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Алтансүхэд:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг цаашид ашиглалтыг хариуцан авч явах байгууллагад шилжүүлэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

АЛБАН ШААРДЛАГА:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 онд 05 сарын 16 өдөр

Дугаар 118 ДДА-2024/18-09-ШТА-ГА Чойбалсан хот
АН-70109

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 9.1-д заасны дагуу Улс, орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн сэдэвт аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 26 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын санд бүртгэлтэй балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2010 оны 04-92 УБА улсын дугаартай Toyota Land cruiser 200 маркийн авто машиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасаж, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газарт буюу төсвийн шууд захирагчид бүртгэж авсан байна. Уг авто машины урсгал засварыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвөөс 30.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн шууд захирагчийн урсгал зардлыг хөрөнгө оруулалтад тусгахгүй ажиллаж, биелэлтийг 2025.04.01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

017041361

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/06

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Б.Батжаргал)-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010145

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны
05 дугаар сарын 16-ны өдрийн
406 дугаар тушаалын хавсралт



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн ЗДТГ	118 ДОА-2024/18-09-ШТА-ГА	30.0
Дүн			

Хавсралт 1

Д-Д	Төсөл, арга хэмжээний нэр	Дүн /мянган төгрөг/
1	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	4,079,807.2
1.1	Шилжих	327,917.8
1.1.1	Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт	25,086.0
1.1.8	Хэрлэн сумын 405, 406 дугаар байранд боловсон ариун цэврийн байгууламж (Хэрлэн сум, 11 дүгээр баг)	53,519.8
1.1.9	Сэвсүүлийн голын гарам, хоолой (Дашбалбар сум)	90,000.0
1.1.10	Дорнод аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал (Багц 2, 3)	66,802.0
1.1.11	Мал эмнэлгийн хорио цээр, ариутгал халдваргүйтгэлийн хяналтын цэг байгуулах ажлын зураг төсвийн зардал (Хөлөнбуйр сум)	12,510.0
1.1.12	Чойбалсан хөгжил ОНӨҮГ-ын авто машины сэлбэг хэрэгсэл худалдан авах	80,000.0
1.2	Шинэ	3,751,889.4
1.2.1	Их засвар	1,082,456.2
1.2.1.2	Хөгжимт драмын театрын үзэгчдийн танхимын шалны засвар (Хэрлэн сум)	105,533.7
1.2.1.7	Соёлын төвийн дээврийн засвар (Баянтүмэн сум)	45,000.0
1.2.1.8	Засаг даргын тамгын газрын барилгын дээврийн засвар /Чойбалсан сум/	89,000.0
1.2.1.11	Дорнод аймаг дахь Политехник коллежийн барилгын дээврийн засвар (Хэрлэн сум 4-р баг)	50,000.0
1.2.1.12	Бага сургуулийн барилгын 1 дүгээр давхрын хэсэгчилсэн засвар /Хэрлэн сум 8 дугаар сургууль/	190,000.0
1.2.1.13	Цэцэрлэгийн халаалтын тогооны засварын ажилд дэмжлэг /Булган/	20,000.0
1.2.1.14	Сургуулийн халаалтын тогооны засварын ажилд дэмжлэг /Чойбалсан сум/	20,000.0
1.2.1.15	Хэвтээ тэнхлэгийн хойд болон урд авто замд хурд сааруулагч хийх, тэмдэглэгээ шинэчлэх /Хэрлэн сум/	140,000.0
1.2.1.16	Тусгаар тогтнолын талбайг өргөтгөх /Хэрлэн сум, 7-р баг/	422,922.5
1.2.2	Барилга, байгууламж	1,169,034.6
1.2.2.2	Эрчим хүчний дэд станц (Хэрлэн сум 2 дугаар баг)	180,757.0

1.2.2.4	Хүүхдийн цэцэрлэгийн гадна зогсоол /Хэрлэн сум 7, 11 дүгээр цэцэрлэг/	70,000.0
1.2.2.5	Спортын талбай (Хэрлэн сум 3, 11 дүгээр баг)	180,000.0
1.2.2.8	Цахилгаан дамжуулах агаарын шугам (Сэргэлэн сум)	40,000.0
1.2.2.9	Соёлын төвийн ариун цэврийн байгууламж (Чулуунхороот сум)	20,000.0
1.2.2.10	Дулаан дамжуулах төв /Хэрлэн сум 4-р баг /	453,277.6
1.2.2.12	Хуучин хогийн цэгийг дарж булшлах ажилд дэмжлэг үзүүлэх/ Баянтүмэн сум /	30,000.0
1.2.2.13	Гүний худгийн цооног гаргах	100,000.0
1.2.2.14	Нийтийн ариун цэврийн байгууламж Чойбалсан сум, Хавирга хилийн боомт	95,000.0
1.2.3	Тоног төхөөрөмж	1,318,398.6
1.2.3.7	Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, тохижилт (Баян-Уул, Гурванзагал сум, Хэрлэн сум 2 дугаар сургууль, 15 дугаар цэцэрлэг)	97,300.0
1.2.3.10	Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслийн засвар	30,000.0
1.2.3.11	Багийн цэцэрлэг, бага сургуулийн боловсон ариун цэврийн байгууламж, гадна тохижилтын ажилд шаардлагатай бараа материал /Хэрлэн сум /	48,000.0
1.2.3.12	Нутгийн захиргааны шинэ барилгын өрөө, танхимд шаардлагатай тоног төхөөрөмж (Хэрлэн сум 7-р баг)	141,118.5
1.2.3.13	Чойбалсан хотын төв авто замд гэрлэн дохио суурилуулах ажилд шаардлагатай тоног төхөөрөмж	70,000.0
1.2.3.14	Зам цэвэрлэгээний тусгай зориулалтын автомашин Чойбалсан хөгжил ОНӨҮГ	350,000.0
1.2.3.15	Авто техникийн шинжилгээний лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж	30,000.0
1.2.3.16	Гүний худгийн цэвэршүүлэх тоног төхөөрөмж /халх гол, буйр нуур /	117,600.0
1.2.3.17	Нутгийн захиргааны шинэ барилгын тохижилтод шаардлагатай тавилга, эд хогшил	220,880.1
1.2.3.18	Явуулын станцын шууд дамжуулалтыг хүлээн авах тоног төхөөрөмж /Баянтүмэн, Хэрлэн сум/	70,000.0
1.2.3.19	Төрийн байгууллагын албан хэрэгцээнд компьютер, тоног төхөөрөмж /Хэрлэн сум /	110,500.0
1.2.3.20	Зөөврийн ариун цэврийн байгууламж /Хэрлэн сум/	33,000.0
1.2.4.	ТЭЗҮ	182,000.0

1.2.4.1	Дорнод аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төсвийн зардал	182,000.0
Төсөвт өртгийг нэмэгдүүлсэн		
1.2.1.4	Орон нутгийн өмчийн барилга,байгууламжийн засвар	58,860.0
1.1.5	Сумдад нэн хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж буй албан хаагчдад зориулсан орон сууцны барилга (Чулуунхороот сум)	27,000.0

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр, 4 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn